

дэж ах Сэнгийн алагдсан мэдээ аваад 5-р Далай ламд санваараа буцаан өргөх үед Далай ламаас Бошигт цолоор шагнагдаад нутагтаа эргэж ирээд Ойрадын хан болж улмаар Халх болон Манжийн эсрэг дайтан тэмцсээр түүний дарагдсан хүртэлх үеийг товчхон гаргасан байна. Дээрхи намтруудаас үзэхэд 1686 оны Хүрэн бэлчирт болсон Халх, Ойрадын феодалуудын чуулган нь шууд Манжийн хааны нөлөөн дор явагдаж Халх, Ойрадын хурцадмал байдлыг түр намжаан Манж өөртөө ашигтай байдал олж авах гэсэн далдын бодлого явуулж байсныг БНМАУ-ын түүхийн дэд¹⁶ ботид тодорхой бичсэн байдаг. Хүрэн бэлчирийн чуулганаас шалтгаалж Галдан бошигт халхыг дайрсан учрыг заваа Дамдин гавьж дээр дурдсан зохиолд тусгай нэмэлт болгон зохиосон «Шастирын сүржан»¹⁷ гэдэг судартаа 4 үндсэн зүйл дээр тулгуурлан бичжээ. Энэ нь Живзүндамба хутагтыг Гандан ши рээтэд найр тавьсангүй хэмээсэн ба Түшээт хан Чахундоржийг Очирт ханд тусалж өөрийг байлдан явсан ба бас Чахундорж охиноо Очирг ханы ач Лувсангомборавданд гэргий болгон өгсөн, Чахундорж Галдан бошигтын дүү Доржжавыг алсан зэрэг 4 өшөөгөөр цэрэг байгуулж халхыг довтолсон гэжээ.

1686—1690 онуудад Халх, Ойрадын хооронд болсон зарим түүхэн үйл явдлыг Өндөр гэгээний намтруудад хэрхэн тусгасныг харьцуулж үзэхэд ийм байна.

ЯПОН ДАХЬ МОНГОЛЫН ЭРТ, ДУНДАД ЗУУНЫ ҮЕИЙН ТҮҮХ СУДЛАЛЫН ТУХАЙД

Т. Мөнхцэцэг

Японд монголын эрт, дундад үеийн түүхийг 1900-гаад оны үеэс судлах болсон байна. Энэ судалгаанд юуны өмнө Монголын түүхийн сурвалж бичгийн судалгаа орно. Нака Мичиёо 1907 онд “Монголын нууц товчоо”-г орчуулж¹ нийтийн хүртээл болгосон нь монгол судлалын талаар японд гарсан анхны дорвитой бүтээл болжээ. Үүний дараахи «Монголын нууц товчоо»-ны томоохон судалгаанд Т. Кобаяши, К. Шираторигийн орчуулга² орох юм. Чухамхүү энэ үеэс уг сурвалжийг хэл, түүх, уран зохиолын талаас судлах явдал өргөжиж түүхийн үүднээс нь К. Ширатори, Ш. Ивамура, М. Мураками, Ж. Ёшида нарын зэрэг олон судлаачид авч үзэх болсон бөгөөд үүнд монголчуудын гарал үүсэлтэй холбоотой домог, газар ус, хүний нэрийн судалгаа голлож байна.

¹⁶ БНМАУ-ын түүх. УБ., 1968. II дэвтэр

¹⁷ chen po hor gyi yul gru' i sngon rabs kyi brjed byang sāstra'i zur rgyang du sog yig las bod skad du bsbyur te bkod pa Делийн хэвлэл 26—27-р тал,

¹ Нака Мичиёо Чингис хааны үнэн тэмдэглэл (Чингис хан жицүроку) Токио. Дайнихон тошө. 1907. Дахин 1943 онд хэвлэгдсэн. Чикума шёбо.

² Кобаяши Такаширо. Монголын нууц түүх. (Мооконо хиши) 1941. Токио. Сэйкапушя. , Ширатори Куракичи. Галигчилсан монголын нууц товчоо (Оняку Мообүн гэнчөо хиши) 1943. Тооёо бүнко

Сүүлийн үед «Монголын нууц товчоо»-ны талаар гарсан томоохон бүтээлийн дотор М. Муракамигийн «Монголын нууц товчоо», Ш. Озавагийн «Монголын нууц товчооны бүрэн тайлбар» гэсэн судалгаа орох юм³.

Энэхүү «Монголын нууц товчоо»-ны судалгааны зэрэгцээ Монголын түүхийн холбогдолтой бусад сурвалж бичгийг орчуулан гаргажээ. Үүнд «Алтан товч»-ийн судалгаа орох юм. М. Ямамото «Алтан товч»-ийг анх орчуулж «Дорно дахины түүхийн судлал» сэтгүүлд цувралаар гаргасан боловч тасалдан бүрэн нийтлэгдээгүй байна.⁴ Харин Т. Кобаяши «Алтан товч»-ийн бүрэн орчуулгыг 1939 онд нийтлүүлсэн ба 1941 онд дахин засварлан хэвлүүлжээ⁵. М. Ямамото «Эрдэнийн товч»-ийг судалж «Маншю шигаку»⁶ сэтгүүлд хэвлүүлсэн бөгөөд Го Минору уг сурвалжийг манж хэлнээс дам орчуулан тайлбар сэлтийн хамт 1940 онд нийтлүүлсэн байна⁷. Эдгээр судалгааны зэрэгцээ хууль цаазын дурсгалыг орчуулан гаргажээ. Үүнд «Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг»-ийг Х. Футаки «Үйсэн дээрх хууль» нэртэйгээр орчуулан зарим тайлбарын хамт хэвлүүлсэн байна.⁸

Эдгээр монголын түүхийн сурвалж бичгийн судалгаанаас харахад холбогдох сурвалжийг орчуулан тайлбарын хамт гаргах хандлага зонхилж байгаа бөгөөд энэ нь нэг талаар Японд монголын түүхийг гүнзгийрүүлэн судлах, түүхийн бүхий л үеийг хамарсан хандлагатай болоход зохих нөлөө үзүүлсэн байна.

Монголын эртний улсуудын талаархи судалгаанд К. Шираторигийн судалгаа орох бөгөөд Хүннүг хэлний талаас нь судалж монгол угсаатанд хамаарна гэж үзжээ.⁹ М. Мори «Хүннүг Азийн түүхэнд нүүдэлчдийн анхны төр улсыг байгуулсан» гэж дүгнэсэн байна.¹⁰ Энэ мэтчилэн Хүннүгээс хойш монгол нутагт төр улсаа байгуулж явсан Сяньби, Жужан, Түрэг, Кидан зэрэг улсуудын талаар судалгаа хийсэн байна. Дээрх судалгаанаас үзэхэд, Төв Азийн нүүдэлч ард түмний гарвалын асуудлыг хүннүгээс эхлэн авч үзэж байгаа нь чухал юм. Гэвч эртний улсын талаар голлон хятад хэл дээр буй Монголын түүхийн холбогдолтой материалд түшиглэн судалгаа хийхдээ түүнд шүүмжлэлтэй хандаагүйгээс зарим үйл явдлыг буруу ташаа тайлбарлах, «соёлтой» суурьшмал, «бүдүүлэг» нүүдэлчин хэмээн зааглан үзэх явдал байна.

³ Мураками Масацүгү. Монголын нууц түүх (монгору хиши) I боть, 1970. II боть, 1972, III боть 1976, Хэйбоншя, Озава Шигэо, Монголын нууц товчооны бүрэн тайлбар. (Гэнчёо хиши но зэншяку). Токио 1984.

⁴ Ямамото Мамору. Чингис хааны үгийн бичиг. (Чингис хан-но кафү) «Тооёо ши кэнкю» сэтгүүлийн 1935 оны 1-р сараас 1936 оны 6-р сарын дугааруудад хэвлүүлжээ.

⁵ Кобаяши Такаширо, Алтан товч монголын он цагийн тэмдэглэл. «Алтан товч-Мооко нэндайки) 1939. Токио, Монголын алтан түүх, Монгол үндэстний сурвалж (Мооко оогонши-мооко минзоку но котэн) 1941.

⁶ Ямамото Мамору. Эрдэнийн товчийн судалгаа (Мооко гэнрюү-но зацухоо) «Маншю шитаку» сэтгүүлийн 2-ын 1938 оны 5, 11. 1939 оны 3-р сарын 1,3,4 дугаарт

⁷ Го Минору. Эрдэнийн товч (Мооко гэнрюү) 1940. Токио

⁸ Х. Футаки. Үйсэн дээрх хууль (Ширакаба хоотэн) Ази Африк хэл соёлын судлал сэтгүүл, 21, 1981. Үйсэн дээрхи хуулийн орчуулга, Тайлбар. I, 1977. Юүбоку шякайши танцүюү, сэтгүүл. 50.

⁹ К. Ширатори. Монгол үндэстний үүсэл (Мооко минзоку-но кигэн) Бүрэн эмхтгэл, IV (Зэншюү 4) Иванами шётэн, 1940, 61-р тал

¹⁰ М. Мори. Нүүдэлчдийн улсын үүсэл хөгжил (Юүбоку кокка-но сэйрицу то хаттэн) Хойд Азийн түүх 12. Ямакава шюрпаня. 1981. 41-р тал

Японы түүх бичлэг дэх монголын эртний улсуудын талаарх судалгаанд нүүдэлчдийн улсыг тус тусад нь салангид авч үзсэнээс, монгол нутаг дээр оршин тогтож, төр улсаа байгуулж явсан улсуудын залгамжлалын асуудлыг орхигдуулжээ.

Тэрчлэн нэгдсэн улс байгуулагдахын өмнөх олон аймаг хоорондоо тэмцэлтэй байсан тухай бичихийн зэрэгцээ Зүрчидийн Алтан улсын зүгээс нүүдэлчдийг хооронд нь тэмцэлдүүлэх, хагаран бутаргах бодлого явуулж байсан талаар судалжээ.¹¹

Япон дахь монголын түүхийн дундад үеийн судалгаанд ХШ зууны монголын нэгдсэн улсын судалгаа нэлээд хувийг эзэлж байна. Монголд нэгдсэн тор байгуулагдсан нь монголын эртний нүүдэлчдийн төр улсуудын нийгэм, эдийн засаг аажим боловч тасралтгүй хөгжиж байсны зүй ёсны үр дүн байв. Энэ үеийн судалгаанд, монголын төрийн зохион байгуулалт болох хишигтэн, мянганы системийн судалгааны зэрэгцээ ХШ зууны үеийн монголын нийгмийн анги давхрагын асуудлыг хөндсөн байна. Тэд хишигтэн, мянганы систем хэдийд буй болсон талаар зөрөөтэй өгүүлж байна. Үүнд нэгдүгээрт, Хэрэйдийг мөхөөсний дараа авч хэрэгжүүлсэн ба нэгдсэн улсын үед улам өргөжиж ирсэн,¹² хоёрдугаарт «Хойд Азийн нүүдэлчдийн дунд эртнээс байсан бөгөөд энэ нь түрэгээс авсан систем юм¹³ гэжээ. Мөн мянгатын системийн шинж чанарыг цэрэг, иргэний гэсэн хоёр талтай байсан талаар нийтээр зөвшөөрч байна. Тэрээр «мянгатын систем нь нийгмийн шаардлагаар гарч ирсэн» гээд «энэ системд орсон нүүдэлчид харъяалагдсан нэгжээс гарахыг хуулиар хатуу хориглосон бөгөөд эдгээр нь хуваан өгсөн газарт хадагдан, цагийн аясаар эрх баригчдынхаа харьяат болон, мянгат зуутын дарга нар ч тэдгээрийг дарангуйлан захирах явдал ямар нэг хэмжээгээр эзний шинж чанартай болж ирэв. Энэ нь эзэнт улс феодалын системд шилжиж байсныг нотлох баримт мөн гэж үзэх хэрэгтэй»¹⁴ гэх буюу «мянгатын системийг байгуулснаар монголын нүүдэлчдийн дунд үндэс бөхтэй байсан овгийн систем ч аажмаар мянгатын системээр солигдож, Чингис хааныг тэргүүнээ болгосон феодалын систем бий болсоор байв»¹⁵ гэжээ. Тэрээр хишигтний талаар өгүүлэхдээ «Хишигтэнд мянгат, зуутын дарга нарын хүүхдүүдийг оруулсан байна. Өөрөөр хэлбэл, хэмжээгүй эрхт эзэн хаан Чингис, шинэ эзэнт улсын дарлагч давхрага болох мянгат, зуутын дарга нарын хооронд бий болсон үнэнч холбоог үр ач нарт нь өвлүүлэн бэхжүүлэх зорилготой байв»¹⁶, «Хишигтэн нь монгол улсын дарлагч давхрагын хүүхдүүд байсан нь анхаарууштай юм. Тэд язгууртан гаралтай байснаар үл барам хишигтэн цэргийн хувьд ч түүний нэр хүнд онцгой эрхээр давхар хангагдаж байв»¹⁷ гэж үзэж байна. Энэ мэтчилэн монголын төрийн зохион байгуулалтын талаар хийсэн судалгаа нэлээд бодитой болжээ. Харин мянгатын системийн үүслийн хувьд тэдний тэмдэглэж байгаачлан монголчууд «Түрэгийн системээс» авсан

¹¹ Дорно дахины түүх. 7. Монголын эзэнт улс. (Дай монгорү тэйкоку), Жинбүшү оорайшя, 1967, 17-р тал -М. Мураками. Монголын эзэнт улсын үүсэл, бутрал дэлхийн түүх Дундад зуун, 3, Иванами шётэн 1970 91-р тал.

¹² М. Мураками. Дэлхийн түүх. 8. Хөх чонын орон (Аоки ооками-но күни) (Токио, 1968, 200, 202-р тал

¹³ Дорно дахины түүх 1. Монголын эзэнт улс, 51-р тал

¹⁴ М. Мураками-Монголын эзэнт улсын үүсэл, бутрал, 104-р тал

¹⁵ Дорно дахины түүх. 7. Монголын эзэнт улс, 52-р тал.

¹⁶ М. Мураками. Монголын эзэнт улсын үүсэл, бутрал, 105-р тал

¹⁷ М. Муракамн. Дэлхийн түүх. 8. Хөх чонын орон. 203-р тал

ч бус, нэгдсэн улсын үед ч анх буй болсон ч бус, энэ нь бүр МЭӨ III зууны үед төр улсаа байгуулсан хүннүгийн үеэс улбаатай юм. Японы судлаачид нэгдсэн улс байгуулагдсан ач холбогдлын талаар «Монгол нутагт оршин байсан тархай бутархай аймаг ханлигуудыг нэгтгэснээр монгол нь эдгээр аймгуудын нийтлэг нэр болсон», Монгол угсаатан бүрэлдэх болж монголын газар нутаг өнөө хүртлэх монголчуудын үндсэн газар нутаг болсон»¹⁸ гэж үзэж байна. Өгэдэй хааны явуулж байсан гадаад дотоод бодлогын талаар нэлээд судалжээ. Тэрээр үндсэн Монгол нутаг болон байлдан эзэлсэн газар нутагт алба татварын системийг газар бүрийн онцлогт зохицуулан гаргасан, монголын нийслэл Хархорумыг байгуулсан, өртөө бий болгосон нь Өгэдэй хааны хийсэн гол ажил байсан гэж тэмдэглэжээ. Монголын эзэнт улсын талаар дээр өгүүлсэн судалгааны зэрэгцээ тухайн үед монголын хаадаас явуулсан байлдан дагууллын түүхийг авч үзээгүй судлаачид ховор байна. Эдгээр судлаачид монголын байлдан дагуулагчдаас өмнө зүгийн орнууд болон өрнө зүг анх довтлох болсон шалтгааныг дотор нь заагтай авч үзэж байна. Тухайлбал Чингис хаан өмнө зүг байлдан дагуулал хийх болсон шалтгааныг «Алтан улс тэдний эцэг өвгөдийн өшөөт дайсан. Иймээс энэхүү өшөөгөө авахын тулд дайтсан»¹⁹ гэх буюу өмнө зүг Хорезм руу дайтах болсон нь «Хорезмын улс Чингисийн худалдаачдыг алж, элчийг доромжлон буцаасан явдал гол шалтгаан болов. Чингис хаан уг нь Хорезм руу дайлах шаардлагагүй байсан юм»²⁰ гэж ихэнх нь тайлбарлаж байна. Гэтэл Чингис хаан болон түүний үе залгамжлагчдын явуулсан дайн нь олз олох гэсэн ноёрхогч ангийг ашиг сонирголоос голлон шалтгаалсан бөгөөд энэхүү байлдан дагуулал нь харь орнууд төдийгүй, монгол орны ард түмэнд асар их хор хөнөөл учруулсан юм. Гэтэл японы түүх бичлэгт энэ үеийг «Монголын түүхийн алтан үе» гэж үзэх явдал байна.

Үүний зэрэгцээ Юан гүрний түүхийг судалжээ. Юан гүрний төрийн эрхийг барьж байсан монгол хаадын улс төрийн бүх үйл ажиллагаа нь эзлэгдсэн орны ард түмнийг боолчлон мөлжихөд чиглэгдсэн юм. Японы судлаачид Юан улс нь монголчууд хятадыг байлдан эзэлсний дүнд бий болсон гэж ихэнх нь үздэг боловч зарим нэг нь «монголчууд хятадыг байлдан эзэлж улмаар нүүдлийн улс төр, эдийн засгийн системийг суурьшил тариалангийн системээр солив»²¹ гэж тайлбарлаж байгаа нь ташаа юм. Хубилай хаан хятадыг эзлэн авч тэнд ноёрхлоо тогтоохын сацуу суурьшил орны иргэдийг тухайн орны нь нөхцөлд тохируулан захирах бодлого баримталж байсан билээ.

XIV—XVII зууны монголын түүхийн талаар Ж. Хагивара, Х. Окада, С. Вада нарын судалгаа голлож байна. Феодалын бутралын үеэр гарсан судалгааг эзэнт гүрний үеийн түүхийн талаар гарсан судалгаатай

¹⁸ Монголын эзэнт улс. Дэлхийн түүхийн цуврал 12. Токио. Сэйкацу бункашя. 1973. 46-р тал, Ш, Ивамура, Т. Кацуфүжи. Их монголын эзэнт улс (Дай мооко тэйкоку) Жинбүчү оорайшя. 1965, 155-р тал Дорно дахины түүх, 7. Монголын эзэнт улс. 11 — 12-р тал

¹⁹ М. Мураками. Монголын эзэнт улсын үүсэл, бутрал, 105-р тал Ш. Ивамура. Т. Кацуфүжи, Их Монголын эзэнт улс, 180-р тал Дорнодахины түүх. 7. Монголын эзэнт улс. 65-р тал

²⁰ Ш. Ивамура, т. Кацуфүжи. Их Монголын эзэнт улс, 181-р тал

М. Мураками. Дэлхийн түүх. 8 Хөх чонын орон. 213-р тал

—М. Мураками. Монголын эзэнт улсын үүсэл, бутрал, 106-р тал

— Дэлхийн түүх. 7. Өрнө нутаг ба Ислам. Чюүкоо бункоо. 1975, 282-р тал.

²¹ Дорно дахины түүх. т, Монголын эзэнт улс, 142-р тал

харьцуулахад харьцангуй бага судлагджээ. Ж. Хагивара XIV-XVII зууны үеийн монголын түүхийг, тухайлбал нүүдэл суурьшил орны эдийн засгийн харилцааны талаар бичсэнээрээ энэ үеийн түүхийн талаар гарсан судалгааны бусад ном зохиолоос өвөрмөц юм. Гэвч зохиогч хятад хэлний сурвалж бичигт шүүмжлэлтэй хандаагүйгээс монголын түүхийн зарим үйл явдлыг ташаа ойлгоход хүрчээ. Мөн өгүүлэн буй үеийн нүүдэлчин монголчууд суурьшил газар тариалангийн орон хятадтай худалдаа хийхдээ «алба»-ын хэлбэрээр худалдаа хийж байсан бөгөөд «Энэхүү алба нь ... эдийн засгийн үүднээс үзэхэд ашигтай худалдаа байв»²² гэсэн байна. Түүнчлэн хятадын засгийн газрын бодлогоос шалтгаалан хилийн худалдаа хаасны дараа хоёр орны ард түмэн хэрэгцээ шаардлагын үүднээс далдуур худалдаа хий дэг байсан талаар бичжээ. Дундад зууны үеийн монгол, хятадын хоорондын худалдааг хятад сурвалж бичигт «алба», «алба барих» гэж тэмдэглэдэг боловч энэ нь үнэн хэрэгтээ биеэ даасан хоёр улсын худалдаа байсан бөгөөд энэхүү «алба» хэмээх нэр томъёог хятадын их гүрний үзлийн илрэл гэж хэлж болох юм.

Монголын нүүдлийн феодализмд үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл нь газар, малаас бүрдэх бөгөөд газар ба малыг эзэмших явдал түүхэн хөгжлийн явцад улам нарийсан хөгжсөөр ирснийг түүхэн баримт нотолж байна. Энэ талаар японы түүхчдийн дунд хоёр янзын санал байгаа бөгөөд үүнд: «Нүүдэлчдийн нийгэмд газар, мал нэгдэн үйлдвэрлэлийн хэрэгсэл болдог. Мал нь үйлдвэрлэлийн хэрэгсэл ч болох, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн ч болох хоёр чанарыг агуулдаг»²³ гэжээ. Гэтэл зарим судлаач «Хээр талд үйлдвэрлэлийн хэрэгслийн хөгжил байгаагүй учраас эдийн засгийн амьдрал нь бүдүүлэг, нүүдлийн ша тандаа байсаар байв»²⁴ гэсэн буруу үзэл баримталж байна. Мөн нүүдэлчдийн үйлдвэрлэлээ явуулах гол нөхцөл болсон бэлчээрийг эзэмшиж буй байдлыг тайлбарлахдаа нэг хэсэг нь «Нүүдэлчид их төлөв тогтмол нүүдэллэдэг»²⁵ гэж байхад, нөгөө судлаачид, нүүдэлчдийн бэлчээр ашиглах явдлыг хялбарчилж бэлчээрийг ямар ч төлөвлөгөө, хувиар заагүй ашигладаг мэтээр үздэг. Нүүдэлчдийн нийгэмд газар үйлдвэрлэлээ явуулах гол нөхцөл нь болдог бөгөөд бэлчээрийг ашиглах явдал феодализм хөгжиж гүнзгийрэхийн хирээр улам нарийссаар иржээ.

Манжийн ноёрхолын үеийн монгол орны талаар судалгаа хомс байна²⁶ Ж. Яно зохиолоо Манжийн төрөөс монголын талаар явуулж байсан бодлого, тухайн үеийн монгол, хятадын харилцаа зэрэг олон асуудлыг хөнджээ. Зохиогч хошууны талаар хийсэн судалгаандаа «хошуу нь монголын ... улс төрийн зохион байгуулалтын нэгж бөгөөд эртнээс монголд байсан систем юм уу гэхэд тийм биш байна.»²⁷ гээд хошуу хэдийд бий болсон талаар өгүүлэхдээ «Мингийн сүүл үеэр бий

22 Ж. Хагивара. Мингийн үеийн монголын түүх судлал. (Миндай моокоши кэнкю. Киото. 1980 60-р тал

23 М. Онуки. Нүүдлийн мал аж ахуйн өнөө үе. (Юүбоку шякай-но гэндэй)

24 Т. Кобаяши. Чингис хаан Иванами шиншө, 1972, 7-р тал

25 Ш. Ивамура, Т. Кацуфүжи. Их монголын эзэнт улс, 161-р тал –

26 Ж. Яно. Орчин үеийн монголын түүх судлал, (Киндай моохо шикэнкюү) Токио, 1925.

— Таяма. Манжийн үеийн монголын нийгмийн байгуулал (Шиндай ни окэру мооко някай сэйдо) Токио, 1954.

27 Ж. Яно. Орчин үеийн монголын түүх судлал, 76-р тал

болсон бөгөөд манж нар үүнийг ашиглаж олон хошуунд хуваав»²⁸ гэсэн байна.

Японы судлаачдын монголын эрт, дунд үеийн түүхийн судалгаанд нүүдэлчин ард түмний соёлын асуудал хөндөгджээ. Монголчуудын соёл нь нүүдэл амьдралын нөхцөлд биеэ даан үүсч хөгжсөн өвөрмөц онцлогтой бөгөөд Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншилд томоохон хувь нэмэр оруулсан билээ. Энэ талаар тэдний дунд хоёр янзын санал байдаг. Үүнд: нэгд, «нүүдэлчид эрт үед ч, одоо ч ямар ч өөрчлөлтгүй, Нэгэн хэвийн амьдралаар амьдардаг²⁹ гэжээ. Хоёрт, «Хээр талын нүүдэлчдийн амьдралыг нарийн харвал үнэхээр малч ард түмэн юм. . . Тэдгээрийн мал маллах соёл ер хүй нэгдлийн соёл биш өндөр соёл»³⁰ юм. Сүү цагаан идээг бэлтгэх арга ажиллагаа болон сүүгээр боловсруулдаг олон нэр төрлийн бүтээгдэхүүн нь монголын хоол хүнсний бахдам соёлын нэг»³¹ гэж үзэж байна.

Нэгдүгээр санал нь тариалан төвийн үзлийн үүднээс хандсан, нүүдэлчдийн нийгэм, эдийн засаг, соёлын биеэ даасан хөгжлийг үгүйсгэсэн үзэл болох нь илэрхий байна. Энэ байдалд японы зарим судлаачид шүүмжлэлтэй хандан «бид нүүдэлчдийг үнэлэхдээ хятадын сурвалжид түшиглэн, хятадын соёлтой жишдэг. Иймээс бид нэг л мэдэхэд нүүдэлчдийг бүдүүлэг гэж үзэхэд хүрдэг. Гэвч дэлхийн түүх хятадыг төвөө болгон хөдөлж байгаа биш болохоор түүхэн үнэлэлтийг өгөхдөө хятадаар хэмжүүр болгох шаардлага байхгүй. Хэл заншил нь эрс ялгаатай учраас тэднийг дутуу гэж үнэлж болохгүй. Бид нүүдэлчдийг авч үзэхдээ хятад хүмүүсийн нүдээр биш, нүүдэлчдийн өөрсдийнх нь байр сууринаас үзэх хэрэгтэй»³² гэжээ.

Мөн Японы түүхчид бүтээлдээ нүүдэл, суурьшил ард түмний харилцааг тусгажээ. Энэхүү харилцаа нь чухал асуудал боловч энэ талаар шинжлэх ухаанч биш үзэл одоо ч байсаар байна. Тэрээр «нүүдэлчид багтаж ядсан энергээ зарцуулахын тулд суурьшил орон руу довтолдог³³, «худалдаа хийхээс гадна дээрэмдэн авах явдал байв. Энэ нь тэдний хувьд чухал үйлдвэрлэлийн хэрэгсэл байв.³⁴ гэхчилэн, нүүдэлчдийн төрөлхийн шинж нь дайн хийхэд оршдог мэтээр гуйвуулан бичжээ. Нөгөө нэг хэсэг нь «нүүдэлчид тариаланчдын харилцаа нь харилцан түшиглэсэн харилцаа юм. Нүүдэлчид тариаланчдыг довтолсон хэрэг нь түүхэнд бичигдэн дамжиж ирсэн байна. Гэтэл хоёр орон тайвнаар зэрэгцэн байсан нь тодорхой боловч энэ нь түүхэнд бичигдээгүй»³⁵ «суурьшил газар тариалангийн оронтой ямар нэг хэмжээгээр харилцдаг боловч, тэдний харилцаа тасалдангүй байдаг. Аливаа харилцаа тогтоох үед нүүдэлчид анх санаачилдаг»³⁶ гэх зэргээр бичиж байгаа боловч нүүдэлчид, тариаланчид хоорондоо зайлшгүй харилцахад хүргэдэг аж ахуйн хоёр өөр хэв шинж, мөн энэхүү харилцааг таслахад хүргэдэг дарлагч ангиудын улс төрийн бодлого зэргийг нягтлаагүйгээс дээрх судалгаа өрөөсгөл болжээ.

28 Мөн зохиол 76-р тал

29 Т. Кобаяши. Чингис хаан, 3-р тал

30 Т. Үмэсао. Ан агнуур ба нүүдлийн ертөнц (Шюрёо то юүбоку-но сэкай) Токио, 1976, 134 — 135-р тал

31 М. Онуки. Нүүдлийн мал аж ахуйн өнөө үе. 62-р тал

32 Ш. Ивамүра, т. Кацуфүжи. Их монголын эзэнт улс 21-р тал

33 Т. Үмэсао. Ан агнуур ба нүүдлийн ертөнц. 153-р тал

34 Т.Кобаяши Чингис хаан 7-р тал

35 Ш, Ивамүра. Т. Кацуфүжи. Дурдсан зохиол 159-р тал

36 Т. Үмэсао. Ан агнуур ба нүүдлийн ертөнц. 135-р тал

Дээр өгүүлснээс нэгтгэн үзэхэд, япон дахь монголын түүх судлалын нэг үндсэн асуудал болох эрт, дунд үеийн түүх судалгаанд түүхэн үйл явдлыг бодитойгоор авч үзэх гэсэн, түүхэн үнэнийг мушгин гуйвуулах гэсэн хоёр чиглэл оршиж байна.

Хятадаас ЗХУ-д ирсэн захидал

Шударга ёсны илд

Одоогоос 50 жилийн өмнө Хятад орны эсрэг милитарист Япон өргөн хүрээтэй түрэмгий дайн явуулж эхэлсэн билээ ... Дор нийтэлж буй захидлын очих хаяг нь ЗХУ, гардуулах эзэд нь Хятадын ард түмний дунд «Шударга ёсны илд» хэмээн алдаршсан Зөвлөлтийн нисгэгч-сайн дурынхан юм. Хятадын тэнгэр дэх тулалдаанаас төрсөн ЗХУ-ын баатар Зөвлөлтийн 14 нисгэгчийн нэг болох дайрагч онгоцны хэсгийн дарга агсан нисэх хүчний бэлтгэл офицер, дэслэгч генерал Алексей Сергеевич Благовещенский уг захидлыг «Литературная газета» сонины редакцид ирүүлсэн байна. 1985 онд А. С. Благовещенский бусад ахмад дайчдын хамт Хятадад айлчилсан бөгөөд Зөвлөлтийн нисгэгчид алдар нэрээ дуурсгасан Ухань хотод очигсоосон аж. Уг захидлын эхийг сийрүүлбэл: «Зөвлөлтийн нисгэгч - сайн дурынхны отрядын эрхэм хүндэт хуучин анд дайчин танаа!

У Динчэнь миний бие та бүхэнтэй мөр зэрэгцэн тулалдаж явсан билээ. Эдүгээ уулзалгүй 40 гаруй жил өнгөрсөн хойно хамтран тэмцэгчид болох зөвлөлтийн нисгэгч - сайн дурынхантай учран золгосондоо зүйрлэшгүй ихээр сэтгэл хөдлөв.

1937 оны сүүлчээр Хятад улсад өөрийн гэсэн онгоц хүрэлцээгүйгээс байдал нэн хүнд байлаа. Америкуудаас тусламж эрсэнд, үнийг бэлнээр төлж, өөрсдөө онгоцоо татаж авах болзол тавьсан нь биднийг мухардалд оруулсан юм. Ийм нөхцөлд манай элэгсэг хөрш ЗХУ гар сунган туслаж бүгд 300 шахам онгоц бидэнд ирүүлсэн билээ. Үүгээр зогсохгүй та бүхэн Хятадад дайрагч, бөмбөгдөгч онгоцны эскадрилийг илгээв. Энэ нь японы нисэх хүчний эсрэг та бидний хамтын тэмцэлд их тус дэм болсон юм. Тэр үед би «И-15», «И-16» гэдэг дайрагч онгоц бүхий 9 дүгээр эскадрилийн нисгэгч явсан. 1938 оны 2 дугаар сарын 18-нд Уханийн тэнгэрт сөрөг хүчинтэй тулалдав. Энэ тулалдаанд бид хамтын хүчээр японы 11 онгоцыг устгаж билээ. «И-15» бол маневрлах чадвар маш сайтай бөгөөд уг тулалдаанд дайсны «96 маягийн» дайрагч онгоц өндрөөс над руу цахилан довтлоход би агшин зуур эргэн ард нь гарч дөрвөн пулемётоороо зэрэг гал нээж дайсны онгоцыг гал утаа болгон сөнөөсөн юм.

Дөрөвдүгээр сарын 29-нд Япон даяар эзэн хааныхаа мэндэлсэн өдрийг тэмдэглэв. Энэ өдөр японы нисэх хүчний дээд командлал Ухань хотыг их хүчээр бөмбөгдөж дээдсээ баярлуулах гэж боджээ. Тэгэхэд та бид хамтын хүчээр японы хоёр эскадрильтай тулалдаж 21 онгоцыг устган гарамгай ялалт байгуулсан билээ. Ялалтын тухай мэдээ орон даяар түгэн, хятад зөвлөлтийн нисгэгчид та бидний алдар нэрийг